



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2022 он | №05

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 539.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн дүн өмнөх оны мөн үеийн алдагдалтай харьцуулахад 327.3 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,217.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,939.7 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 537.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн бол өмнөх оны мөн үеэс 634.0 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар нэмэгдсэн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 91.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 537.5 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд татварын орлого 5.7 хувь буюу 341.5 тэрбум, татварын бус орлого 37.3 хувь буюу 196.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу биелсэнтэй холбоотой байна.
- Тайлант хугацаанд орлогын албан татвар, тусгай зориулалтын орлого болон гадаад үйл ажиллагааны орлогоос бусад төрлийн татварын орлого 2.1-21.4 хувиар төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 196.0 тэрбум төгрөгөөр дутуу биелснээр 62.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хувьцааны ногдол ашиг болон хөрөнгийн орлогоос бусад төрлийн татварын бус орлого төлөвлөсөнд хүрч биелээгүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 6,478.7 тэрбум төгрөг болж 1,755.2 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 78.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 21.3 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар буюу 306.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 42.7 хувийн гүйцэтгэлтэй гарч 169.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бол концессын эргэн төлөлтөд 175.3 тэрбум төгрөг зарцуулагдаж 73.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 56.6 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 151.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 396.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 169.4 тэрбум төгрөгийг зарцуулж 42.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 539.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 5,939.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 6,478.7 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 539.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 327.3 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 1,217.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 356.4 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 189.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 80.0 тэрбум, ирээдүйн өв сангийн орлого 173.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн бол нийгмийн даатгалын сангийн орлого 44.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувь буюу 634.0 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 5.0 хувь буюу 306.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 7.0 пунктээр их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 327.3 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү.
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,163.3	390.4	283.5	72.6	-106.9
Засгийн газрын бонд	-90.5	490.3	0.0	0.0	-490.3
Засгийн газрын зээл	-206.8	570.8	255.4	44.7	-315.4
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	305.2	0.0	0.0	-305.2
Өмч хувьчлал	0.2	0.0	0.1	0.0	0.1
НИЙТ ДҮН	866.3	1,756.6	539.0	30.7	-1,217.6

Эх сурвалж: Сангийн яам

2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 233.2 тэрбум төгрөг төлсөн бол бондын төлбөрт 22.5 сая төгрөг төлөгдөж, 488.6 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 126.0 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 5,939.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувь буюу 634.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 8.3 хувь буюу 537.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл нийгмийн даатгалын сан 3.5 хувь буюу 44.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс давж биелсэн бол улсын төсөв 9.1 хувь буюу 356.4 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 15.3 хувь буюу 189.3 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 13.2 хувь буюу 80.0 тэрбум төгрөгөөр, Ирээдүйн өв сан 27.8 хувь буюу 173.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 8.3 хувь буюу 319.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 25.3 хувь буюу 354.7 тэрбум төгрөгөөр буурсан бол нийгмийн даатгалын сангийн орлого 30.5 хувь буюу 304.5 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 34.6 хувь буюу 134.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь татварын орлого 0.1 хувь буюу 4.9 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 56.3 хувь буюу 351.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалжээ. Тодруулбал, улсын төсвийн татварын бус орлогыг бүрдүүлдэг орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн орлого 83.2 хувь буюу 180.8 тэрбум төгрөг, газрын тосны орлого 99.2 хувь буюу 108.6 тэрбум төгрөгөөр буурсан нь тус тус нөлөөлжээ.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС		ИӨС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,216.2	4,130.3	1,234.8	1,045.5	1,258.2	1,302.3	604.5	524.5	622.9	449.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	305.2	575.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,911.0	3,554.6	1,234.8	1,045.5	1,258.2	1,302.3	604.5	524.5	622.9	449.5
Татварын орлого	3,287.0	3,282.1	909.7	770.1	939.3	983.4	604.5	524.5	622.9	449.5
Орлогын албан татвар	586.4	739.9	675.1	544.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	939.3	983.4	604.5	524.5	0.0	0.0
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	105.8	89.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,453.7	1,418.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	438.4	378.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	5.4	7.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	448.0	454.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	355.3	283.6	128.8	137.1	0.0	0.0	0.0	0.0	622.9	449.5
Татварын бус орлого	624.0	272.5	325.1	275.4	318.9	318.9	0.0	0.0	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	327.4	182.4	135.4	92.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	1.0	2.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	79.3	53.6	2.3	0.0	318.9	318.9	0.0	0.0	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	217.3	36.5	186.5	180.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 94.4 хувийг татварын орлого, 5.6 хувийг татварын бус орлого эзэлж байна.


“

Татварын орлого 5,610.0 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 5.3 хувь буюу 341.5 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 22.9 хувь буюу 1,046.5 тэрбум төгрөгөөр өссөн бол татварын бус орлого 55.6 хувь буюу 412.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Татварын орлогын 22.9 хувийг орлогын албан татвар, 19.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.6 хувийг хөрөнгийн албан татвар, 25.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 6.8 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 15.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 5.7 хувь буюу 341.5 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд нийгмийн даатгалын орлого 2.1 хувь (23.7 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 15.8 хувь (16.7 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 2.5 хувь (35.7 тэрбум төгрөг), онцгой албан татвар 13.6 хувь (59.6 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр хураамжийн орлого 21.4 хувиар (236.7 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу биелсэн нь нөлөөлжээ. Тодруулбал, онцгой албан татварыг бүрдүүлэх автобензин, дизель түлшний онцгой албан татвар төлөвлөснөөс 44.4 хувь буюу 63.2 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ. Мөн бусад татвар, төлбөр хураамжийн орлогын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 24.4 хувь буюу 224.5 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ. Энэ нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалтын улмаас БНХАУ-ын хилийн хоригтой холбоотой эрдэс бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ буурснаас шалтгаалсан байна.

Төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын албан татвар 1.8 хувь (22.9 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 43.4 хувь (2.3 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 1.4 хувиар (6.2 тэрбум төгрөг) тус тус давж биелсэн байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр татварын орлого 22.9 хувь буюу 1,046.5 тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 41.0 хувь (322.0 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 32.1 хувь (21.7 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 35.3 хувь (370.0 тэрбум төгрөг), онцгой албан татвар 19.7 хувь (62.2 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 48.7 хувь (2.5 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 30.8 хувь (106.9 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 1.4 дахин (501.4 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

“**Татварын бус орлого 329.7 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 412.5 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 196.0 тэрбум төгрөг буюу 37.3 хувиар дутуу биелжээ.**”

Төлөвлөгөөтэй харьцуулахад төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 1.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, гадаад хандив тусламжийн орлого 28.0 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Харин нийтлэг татварын бус орлогоос хувьцааны ногдол ашиг 5.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол хүүгийн орлого 0.9 тэрбум төгрөг, торгуулийн орлого 7.9 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 11.0 тэрбум төгрөг, түрээсийн орлого 117.0 сая төгрөг, газрын тосны орлого 108.6 тэрбум төгрөг, навигацгийн орлого 26.5 тэрбум төгрөг, бусад орлого 19.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 83.4 хувийг нийтлэг татварын бус орлого, 16.0 хувийг тусламжийн орлого, 0.6 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 2.6 хувийг хувьцааны ногдол ашгийн орлого, 4.2 хувийг хүүгийн орлого, 15.4 хувийг торгуулийн орлого, 51.1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.5 хувийг түрээсийн орлого, 0.6 хувийг газрын тосны орлого, 5.8 хувийг навигацгийн орлого эзэлсэн бол 19.7 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө 37.3 хувиар дутуу биелэхэд нийтлэг татварын бус орлогын нэг төрөл болох газрын тосны орлого 98.4 хувь буюу 108.6 тэрбум төгрөгөөр тасалдсан нь гол нөлөө үзүүлжээ. Манай улсын түүхий газрын тосны экспорт буурсан нь БНХАУ-д цар тахлын тархалт ихэссэнээс шалтгаалж өнгөрсөн оны 11 дүгээр сараас эхлэн тус улсын хилээр түүхий газрын тос нэвтрүүлэхийг хориглосон хэвээр байгаагаас шалтгаалжээ.

“**Татварын ерөнхий газар орлогын төлөвлөгөөг 4.2 хувиар, Таалийн ерөнхий газар 1.3 хувиар дутуу биелүүлсэн үзүүлэлттэй байна.**

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 20 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 9 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 11 нь 3.7-81.0 хүртэл хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2022 оны эхний 5 сар			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Сангийн сайд	4,294,466.7	4,770,566.7	4,592,272.2	-178,294.5	96.3
Татварын ерөнхий газар	2,563,750.5	2,961,388.6	2,837,557.0	-123,831.5	95.8
Үүнээс: Тогтворжуулалтын санд	218,703.7	305,174.9	575,670.0	270,495.1	188.6
Гаалийн ерөнхий газар	1,315,384.8	1,689,290.5	1,666,855.8	-22,434.7	98.7
Сангийн яам	377,137.3	39,739.5	32,689.3	-7,050.2	82.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	35,244.6	78,382.6	52,686.0	-25,696.6	67.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,949.5	1,765.5	2,484.0	718.6	140.7
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	0.0	77.1	72.7	-4.4	94.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	77.1	72.7	-4.4	94.3
Монгол Улсын Ерөнхий сайд	3,240.5	2,740.7	1,301.2	-1,439.5	47.5
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	2,872.2	2,402.6	506.3	-1,896.3	21.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	368.4	338.1	794.9	456.8	235.1
Монгол Улсын Шадар сайд	6,316.9	4,924.3	5,208.2	283.8	105.8
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	1,098.8	820.5	540.5	-280.0	65.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,218.1	4,103.8	4,667.6	563.8	113.7
Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,903.0	21,249.1	21,280.7	31.6	100.1
Улсын бүртгэлийн ерөнхий газар	6,337.3	8,836.8	7,286.8	-1,550.0	82.5
Цагдаагийн ерөнхий газар	448.3	2,083.3	742.5	-1,340.8	35.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	3,372.1	560.2	538.5	-21.7	96.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	10,745.3	9,768.8	12,712.8	2,944.0	130.1
Гадаад харилцааны сайд	3,035.9	2,657.4	881.7	-1,775.7	33.2
Дипломат төлөөлөгчийн газрууд	3,025.5	2,657.4	881.7	-1,775.7	33.2
Зам, тээврийн хөгжлийн сайд	27,464.5	50,471.4	20,824.5	-29,646.9	41.3
Иргэний нисэхийн ерөнхий газар	25,500.0	42,500.0	16,000.0	-26,500.0	37.6
Зам, тээврийн хөгжлийн яам	90.0	82.1	100.0	17.9	121.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,874.5	7,889.3	4,724.5	-3,164.8	59.9
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	109,168.5	133,495.6	32,333.6	-101,162.1	24.2
Ашигт малтмал, газрын тосны газар	108,155.2	133,145.6	31,444.8	-101,700.8	23.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,013.3	350.0	888.8	538.8	253.9
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	14,457.4	22,033.7	16,104.8	-5,928.9	73.1
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	252.3	182.5	-69.8	72.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	274.3	332.7	376.7	44.0	113.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	14,183.1	21,448.7	15,545.6	-5,903.1	72.5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	37,761.2	30,436.3	25,094.6	-5,341.7	82.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	37,761.2	30,436.3	25,094.6	-5,341.7	82.4
Эрүүл мэндийн сайд	1,373.3	2,274.1	2,868.6	594.5	126.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,373.3	2,274.1	2,868.6	594.5	126.1
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1,081.6	119.5	1,354.4	1,234.9	1133.2

Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,081.6	119.5	1,354.4	1,234.9	1133.2
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	3,298.0	50.0	77.8	27.8	155.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,298.0	50.0	77.8	27.8	155.7
Боловсрол, шинжлэх ухааны сайд	1,239.2	1,977.7	898.1	-1,079.5	45.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,239.2	1,977.7	898.1	-1,079.5	45.4
Барилга, хот байгуулалтын сайд	375.0	895.1	250.0	-645.1	27.9
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	375.0	815.1	250.0	-565.1	30.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	80.0	0.0	-80.0	0.0
Батлан хамгаалахын сайд	25,324.5	13,224.0	21,229.8	8,005.9	160.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	23,596.0	13,224.0	21,229.8	8,005.9	160.5
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	102.0	50.0	229.5	179.5	459.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	102.0	40.0	188.3	148.3	470.7
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1,778.7	1,128.8	2,171.0	1,042.2	192.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,778.7	1,128.8	2,171.0	1,042.2	192.3
Эдийн засгийн хөгжлийн сайд	0.0	2,507.1	475.6	-2,031.5	19.0
Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	0.0	2,323.3	0.0	-2,323.3	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	183.8	475.6	291.8	258.8
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	0.0	3,326.7	5,259.0	1,932.3	158.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	3,326.7	5,259.0	1,932.3	158.1

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 306.6 тэрбум төгрөг буюу 5.0 хувиар өсөж 6,478.7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,233.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 78.7 хувийг зарлагдаж, 1,755.2 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 306.6 тэрбум төгрөг буюу 5.0 хувиар өсөж 6,478.7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС		ИӨС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,111.9	3,882.2	1,533.5	725.2	1,347.5	1,318.7	772.3	873.1	622.9	616.2
НИЙТ ЗАРЛАГА	5,175.4	3,848.4	1,500.7	722.1	1,372.0	1,322.0	892.3	874.5	622.9	616.2
УРСГАЛ ЗАРДАЛ	3,933.6	3,146.7	1,052.7	583.0	1,372.0	1,322.0	892.3	874.5	622.9	616.2
Бараа, ажил, үйлчилгээний зардал	1,323.5	925.5	643.7	450.4	15.4	10.5	9.6	8.8	0.0	0.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	433.3	275.8	22.7	9.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	501.4	451.0	78.0	51.8	0.0	0.0	32.8	38.4	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	1,675.4	1,494.4	308.3	71.3	1,356.6	1,311.4	849.9	827.3	622.9	616.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,241.8	701.7	447.9	139.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-63.5	33.9	32.8	3.1	-24.5	-3.3	-120.0	-1.4	0.0	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,200.8	-327.6	-298.7	320.3	-89.3	-16.4	-167.8	-348.6	0.0	-166.6

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,229.6 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 808.3 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 28.8 тэрбум, ирээдүйн өв сангийн зарлага 6.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 100.9 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс нийгмийн даатгалын сангийн зарлага 271.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 481.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж зарцуулагдсан бол улсын төсвийн зарлага 1,219.2 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 263.5 тэрбум төгрөгөөр бага зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 5.0 хувь буюу 306.6 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 7.2 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 145.3 тэрбум, хөрөнгийн зардал 168.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувь буюу 56.6 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 34.8 хувь буюу 151.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,172.1	8,233.9	6,478.7	-21.3	-1,755.2
НИЙТ ЗАРЛАГА	6,132.7	8,409.1	6,446.5	-23.3	-1,962.6
УРСГАЛ ЗАРДАЛ	5,460.4	6,719.4	5,605.7	-16.6	-1,113.7
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,611.8	1,920.4	1,334.9	-30.5	-585.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998.6	770.7	681.8	-11.5	-88.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128.7	176.7	147.4	-16.6	-29.3
Хангамж, бараа материалын зардал	58.0	80.0	65.7	-17.9	-14.3
Нормативт зардал	60.9	130.0	94.1	-27.6	-35.8
Эд хогшил, урсгал засварын зардал	16.8	68.9	29.7	-57.0	-39.3
Томилолт, зочны зардал	3.1	13.2	7.4	-43.9	-5.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	203.8	440.8	191.9	-56.5	-248.9
Бараа үйлчилгээний бусад зардал	141.9	240.0	116.9	-51.3	-123.2
ХҮҮ	341.9	437.2	285.3	-34.8	-151.9
ТАТААС	170.9	293.3	222.3	-24.2	-71.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,335.8	4,068.4	3,763.2	-7.5	-305.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	278.6	2,145.7	2,045.4	-4.7	-100.3
Бусад урсгал шилжүүлэг	3,057.2	1,922.7	1,717.7	-10.7	-205.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	672.3	1,689.8	840.8	-50.2	-849.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	39.4	-175.2	32.3	-118.4	207.5


Эх сурвалж: Сангийн яам

“
Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 86.5 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.9 пунктээр буурсан байна.
 ”

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 87.0 хувь буюу 5,605.7 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 67.1 хувийг урсгал шилжүүлэг, 23.8 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 5.1 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.0 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 145.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардал 276.9 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 56.6 тэрбум төгрөгөөр буурсан ч татаас 51.4 тэрбум, урсгал шилжүүлэг 427.3 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц
 /Хувиар/



“
Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар 35 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлага 1,229.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 75.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
 ”

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 25.2 хувийг Сангийн сайдын багц, 20.3 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 15.7 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 10.5 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 6.6 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 21.8 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	8,571.8	5,219.3	-3,352.6	60.9
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	29,458.8	24,633.9	-4,825.0	83.6
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	125,089.3	62,211.3	-62,878.0	49.7
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	29,080.2	12,327.6	-16,752.6	42.4
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	56,218.5	40,488.2	-15,730.3	72.0
САНГИЙН САЙД	1,385,132.3	977,452.0	-407,680.3	70.6
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	122,588.8	103,492.8	-19,096.0	84.4
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	449,368.1	408,196.2	-41,171.9	90.8
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,312.6	1,023.5	-289.1	78.0
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,155.2	1,807.8	-2,347.4	43.5
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	34,692.3	24,991.6	-9,700.7	72.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	27,415.6	17,086.7	-10,328.9	62.3
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	5,558.7	5,214.4	-344.3	93.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	11,141.8	8,060.3	-3,081.5	72.3
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	8,445.1	6,203.6	-2,241.5	73.5
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	3,344.9	2,369.7	-975.1	70.8
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	794.5	696.5	-98.0	87.7
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	12,759.3	12,683.9	-75.3	99.4
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	95,428.5	67,322.0	-28,106.4	70.5
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	4,731.7	1,047.2	-3,684.5	22.1
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	1,149.4	780.8	-368.6	67.9
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	15,772.9	9,815.0	-5,957.9	62.2
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	45,851.0	20,852.8	-24,998.2	45.5
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	305,118.7	255,647.3	-49,471.5	83.8
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	60,157.8	21,039.3	-39,118.5	35.0
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	940,974.6	786,632.4	-154,342.2	83.6
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	94,946.5	58,352.0	-36,594.5	61.5
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	6,894.5	5,049.1	-1,845.4	73.2
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	124,387.3	75,525.1	-48,862.3	60.7
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	66,719.8	52,914.4	-13,805.4	79.3
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	709,392.3	608,458.4	-100,933.9	85.8
СОЁЛЫН САЙД	67,479.5	41,194.4	-26,285.1	61.0
ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО	1,542.3	1,150.9	-391.4	74.6
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	241,128.3	156,141.1	-84,987.2	64.8
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	15,068.4	6,151.2	-8,917.2	40.8
НИЙТ ЗАРДАЛ	5,111,871.4	3,882,232.6	-1,229,638.7	75.9

Эх сурвалж: Сангийн яам

2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 396.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 169.4 тэрбум төгрөгийг зарцуулж 42.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2022 онд нийт 1,393.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 396.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 169.4 тэрбум төгрөгийг зарцуулж 42.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2022 оны төсөв	2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	712.7	512.7	177.8	334.9	34.7
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	2,114.5	1,200.0	0.0	1,200.0	-
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	46,983.6	14,804.4	2,475.1	12,329.3	16.7
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	9,147.9	3,880.7	1,423.3	2,457.3	36.7
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	21,770.2	9,266.9	2,243.5	7,023.4	24.2
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	17,774.6	6,129.4	624.0	5,505.4	10.2
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	12,457.4	5,013.9	1,832.3	3,181.5	36.5
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	8,400.0	7,920.0	7,896.9	23.1	99.7
IX	САНГИЙН САЙД	77,353.2	14,674.0	1,181.9	13,492.1	8.1
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	62,746.1	25,887.6	17,143.3	8,744.4	66.2
XI	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	28,827.9	11,994.1	5,700.1	6,294.0	47.5
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	223,270.4	51,376.5	13,889.2	37,487.3	27.0
XIII	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	356,973.8	88,087.3	43,218.1	44,869.2	49.1
XIV	СОЁЛЫН САЙД	74,425.8	15,822.7	4,352.2	11,470.5	27.5
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	230,790.6	68,661.2	42,090.6	26,570.6	61.3
XVI	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	1,354.7	600.0	0.0	600.0	-
XVII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	41,307.8	11,689.4	2,541.9	9,147.5	21.7
XVIII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	80,913.6	20,835.6	9,973.0	10,862.6	47.9
XIX	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	72,898.9	25,463.8	10,408.9	15,054.9	40.9
XX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	1,043.0	600.0	66.4	533.6	11.1
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	743.8	600.0	0.0	600.0	-
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4,000.0	2,400.0	0.0	2,400.0	-
XXIII	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	6,219.5	2,830.6	398.3	2,432.2	14.1
XXIV	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	2,158.2	1,400.0	1,222.7	177.3	87.3
XXII	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	1,526.1	900.0	219.3	680.7	24.4
XXIII	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	1,000.0	600.0	377.1	222.9	62.9
XXIV	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	142.0	142.0	0.0	142.0	-
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	114.5	114.5	0.0	114.5	-
XXIV	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	6,384.8	2,819.0	0.0	2,819.0	-
XXIV	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	200.0	200.0	0.0	200.0	-
НИЙТ		1,393,755.5	396,426.2	169,455.9	226,970.3	42.7

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх 303.6 тэрбум төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 238.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 175.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 73.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны төсөв	2022 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	303,600.0	238,375.3	175,339.0	63,036.3	73.6
Концессын төслийн эргэн төлөлт	303,600.0	238,375.3	175,339.0	63,036.3	73.6
I.Барилга байгууламж	303,600.0	238,375.3	175,339.0	63,036.3	73.6
<i>Шилжих</i>	<i>253,868.4</i>	<i>211,771.3</i>	<i>148,735.6</i>	<i>63,035.7</i>	<i>70.2</i>
Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл	62,797.2	42,797.2	24,023.1	18,774.1	56.1
Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл	94,478.1	88,874.1	45,000.0	43,874.1	50.6
Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл	87,593.1	76,000.0	75,708.7	291.3	99.6
Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам	9,000.0	4,100.0	4,003.9	96.1	97.7
<i>Шинэ</i>	<i>49,731.6</i>	<i>26,604.0</i>	<i>26,603.3</i>	<i>0.7</i>	<i>100.0</i>
Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл /Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/	25,000.0	25,000.0	25,000.0	0.0	100.0
Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл	22,969.6	0.0	0.0	0.0	-
Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төсөл	1,762.0	1,604.0	1,603.3	0.7	100.0

Эх сурвалж: Сангийн яам



5. Нийгмийн даатгалын сан

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН




↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 1,318.7 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 271.7 тэрбум төгрөг буюу 26.0 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 280.1 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 4.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3.3 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 110.3 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого: 2022 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 1,302.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 3.5 хувь буюу 44.1 тэрбум төгрөгөөр давж биелэн орлогын гүйцэтгэл 103.5 хувьтай гарчээ.

График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/




Ирээдүйн өв санд 449.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөсөнтэй харьцуулахад 173.3 тэрбум төгрөгөөр дутуу буюу 72.2 хувийн гүйцэтгэлтэй биелсэн байна. Тус сангаас 616.2 тэрбум төгрөгийн зарлага гарсан нь төлөвлөснөөс 6.7 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна. Ирээдүйн өв сангийн орлого төлөвлөгөөнд хүрээгүй нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

6. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 13.2 хувиар дутуу биелжээ.


График 6. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2022 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр 524.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 13.2 хувь буюу 80.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 873.1 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 481.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2022 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 772.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 873.1 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 113.1 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 481.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 808.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2022 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 1,045.5 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 15.3 хувь буюу 189.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 725.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 52.7 хувь буюу 808.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 320.3 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 25.3 хувиар буюу 354.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 26.7 хувь буюу 263.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


Орон нутгийн төсвийн нийт орлогын 82.7 хувийг орон нутгийн төсвийн орлого, 8.9 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 8.4 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 92.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 99.9 хувьтай гарсан бол орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 93.7 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 88.0 тэрбум төгрөг буюу 93.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 9. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	7,779.1	7,779.1	100.0	3,005.7	2,924.9	97.3
Баян-Өлгий	5,701.4	5,701.4	100.0	2,514.7	2,436.4	96.9
Баянхонгор	8,494.8	8,494.8	100.0	4,306.6	3,945.9	91.6
Булган	3,219.2	3,219.2	100.0	2,466.3	2,285.6	92.7
Говь-Алтай	7,456.3	7,456.3	100.0	3,999.3	3,773.1	94.3
Дорноговь	0.0	0.0	0.0	6,847.3	5,686.5	83.0
Дорнод	0.0	0.0	0.0	5,935.1	5,268.1	88.8
Дундговь	5,753.4	5,753.4	100.0	3,131.0	3,051.8	97.5
Завхан	7,097.5	7,097.5	100.0	2,842.0	2,685.3	94.5
Өвөрхангай	8,669.6	8,669.6	100.0	3,554.3	3,437.5	96.7
Өмнөговь	0.0	0.0	0.0	7,323.9	6,533.5	89.2
Сүхбаатар	3,542.8	3,491.0	98.5	4,790.2	4,695.9	98.0
Сэлэнгэ	0.0	0.0	0.0	4,995.6	4,803.9	96.2
Төв	5,247.1	5,247.1	100.0	4,857.4	4,526.9	93.2
Увс	7,586.6	7,586.6	100.0	2,836.8	2,567.0	90.5
Ховд	4,620.9	4,620.9	100.0	4,179.3	4,083.4	97.7
Хөвсгөл	10,633.7	10,633.7	100.0	3,743.8	3,613.7	96.5
Хэнтий	6,087.9	6,087.9	100.0	3,274.2	3,136.1	95.8
Дархан-Уул	0.0	0.0	0.0	3,830.9	3,765.5	98.3
Улаанбаатар	0.0	0.0	0.0	10,075.6	9,718.3	96.5
Орхон	0.0	0.0	0.0	3,947.3	3,848.8	97.5
Говьсүмбэр	836.3	836.3	100.0	1,286.7	1,247.3	96.9
ДҮН	92,726.6	92,674.8	99.9	93,744.0	88,035.5	93.9

Эх сурвалж: Сангийн яам



Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 189.3 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн орлого 17.5 хувь буюу 183.5 тэрбум төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 0.1 хувь буюу 51.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 6.1 хувь буюу 5.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн нийт орлогыг аймгуудаар харуулбал: Архангай аймаг 2,078.3 сая, Баян-Өлгий аймаг 1,322.1 сая, Баянхонгор аймаг 1,772.2 сая, Говь-Алтай аймаг 149.9 сая, Дорнод аймаг 5,537.5 сая, Дундговь аймаг 1,175.9 сая, Өвөрхангай аймаг 3,268.6 сая, Өмнөговь аймаг 136,713.6 сая, Сүхбаатар аймаг 6,021.0 сая, Сэлэнгэ аймаг 8,822.1 сая, Увс аймаг 1,086.1 сая, Ховд аймаг 3,279.4 сая, Улаанбаатар хот 33,642.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн бол Булган аймаг 1,007.2 сая, Дорноговь аймаг 4,833.4 сая, Завхан аймаг 857.6 сая, Төв аймаг 2,031.3 сая, Хөвсгөл аймаг 957.9 сая, Хэнтий аймаг 3,541.6 сая, Говьсүмбэр аймаг 207.1 сая, Дархан-Уул аймаг 696.5 сая, Орхон аймаг 1,448.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.